



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 03 өдөр

Дугаар №107

Есөнбулаг

Г Комисс томилох тухай **Д**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангияллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн Цээл сумын шинэ суурышлын бүсэд хийгдсэн цэвэрлэх байгууламжийн угсралт, суурилуулалтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)
Гишүүдэд:	М.Мандаххүү	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	Б.Лхагва-Очир	(Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)
	П.Азаяа	(Онцгой байдлын газрын тал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч)
	Б.Батбилэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн улсын байцаагч)
	Ж.Билэгсайхан	(Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)
	Д.Баярчулуун	("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн ерөнхий инженер)
	Д.Буянхишиг	(Цээл сумын Засаг дарга)
	Б.Насанбуян	(Цээл сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

2.

Ц.Нямдаваа ("Чингисийн дуулга" ХХК-ийн захирал) (гүйцэтгэгч)
Ч.Манлайбаатар ("Дэрвэн түн" ХХК-ийн захирал) (зохиогч)
Нарийн бичгийн дарга: Б.Цэрэндаваа (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Барилга байгууламжийн угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нехцэл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3. Холбогдох акт, баримт бичгийг үндэслэн орон нутгийн өмчид бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), барилга байгууламжийн ургал зардлыг төсөвт тусгаж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Цээл сумын Засаг дарга (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

